



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны ᠐1 сарын ᠒᠐ өдөр

Дугаар 109

Шивээговь сум

Малчдад цол тэмдэг, батламж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, 3.1.8, “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.4, 3.1.4, 5.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрдэнэт мал сүргийнхээ тоо толгой өсгөж, малын ашиг шимийн гарц, чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлж сумын “Аварга малчин”-аар Шивээговь сумын 2 дугаар багийн малчин Зундуйн Жаргалсайхан, Рэгзэнгийн Оюунчулуун, Цэндбазарын Мэндбаяр нарыг шалгаруулж цол, тэмдэг, малчин Мягмарсүрэнгийн Алтангэрэлд “Сумын мянгат малчин”-ы батламж, тэмдгийг тус тус олгосугай.


2. Шагналын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах (нэг сая дөрвөн зуун гучин мянга) 1,430,000 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын оны 01
сарын 20-ны өдрийн 1709 дугаар
захирамжийн хавсралт



ШАГНАЛЫН ТӨСӨВ

2022.01.20

№	Малчны овог нэр	Материал	Нийт үнэ, төгрөг
Сумын "Аварга малчин"			
1	Зундуйн Жаргалсайхан	Малгай, үнэмлэх, үнэ бүхий зүйл	320,000
2	Рэгзэнгийн Оюунчулуун	Үнэ бүхий зүйл	320,000
3	Цэндбазарын Мэндбаяр	Үнэ бүхий зүйл	320,000
Сумын "Мянгат малчин"			
4	Мягмарсүрэнгийн Алтангэрэл	Батламж, тэмдэг, үнэ бүхий зүйл	470,000
Нийт			1,430,000